

# Нас барагсдын төлөөх ХОЖМЫН ҮЕИЙН АЖИЛ



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жон А.Видцоу (1872–1952) нь Бурханы охид, хөвгүүдийг аврахад туслах, бидний урьдчилан томилогдсон номлолын талаар дараах зүйлийг заасан байна.

“Бид мөнх бус оршихуйн өмнөх байдалдаа, агуу зөвлөгөөний өдөр, Бүхнийг чадагчтай тодорхой нэгэн гэрээ байгуулсан юм. Их Эзэн өөрийнхөө бий болгосон нэгэн төлөвлөгөөг танилцуулсан билээ. Бид үүнийг хүлээн авсан. Төлөвлөгөө нь хүн бүрд зориулагдсан байсан учраас бид энэ төлөвлөгөөн дэх хүн бүрийн авралын нэгэн хэсэг болсон юм. Бид яг тэр үед, тэнд байхдаа зөвхөн өөрсдийн аврагч байгаад зогсохгүй, бас бүх хүн төрөлхтний аврагч байна гэсэн гэрээ хийсэн. Бид Их Эзэний хамтрагчид болсон юм. Энэ төлөвлөгөө хэрэгжих эсэх нь зөвхөн Эцэгийн ажил, бас Аврагчийн ажил байхаас гадна бидний ажил болсон юм. Бидний өчүүхэн хэсэг, номхон хүлцэнгүй тэр хүмүүс нь авралын мөнхийн төлөвлөгөөний зорилгыг биелүүлэхийн тулд Бүхнийг Чадагчийн хамтрагчид болсон байдаг (“The Worth of Souls,” *Utah Genealogical and Historical Magazine*, 1934 оны 10-р сар, 189)” (*Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх: сайн мэдээний сургаалын багшийн гарын авлага* [1999], 173).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт нь Сүмийн өсвөр үеийнхнийг өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ажлыг хийхэд урамшуулан дэмжсэн:

“Ариун сүмд таны хийдэг ямар ч ажил таны цагийг дэмий гарзадна гэж байхгүй, харин өвөг дээдсийнхээ хэн нэгний төлөө төлөөлөн гүйцэтгэх ёслол хийлгэснээр ариун сүмд өнгөрүүлсэн цаг тань улам ариун болж, агуу адислалууд хүлээн авах боломжийг танд олгоно. . . .

“Залуу хүмүүс та нар дайсны нөлөөг амьдралаасаа шахан зайлуулах найдвартай арга замыг мэдэхийг хүсэж байна уу? Тэгвэл өвөг дээдсээ эрж олон, тэдний нэрийг ариун сүмийн төлөөлөн гүйцэтгэх ёслолуудад бэлтгэж, улмаар ариун сүмд очиж, тэдний төлөө баптисмын болон Ариун Сүнс хүлээн авах ёслолуудыг хийлгэхэд бие сэтгэлээ дайчлан ажиллагтун. . . . Амьдралд тань нөлөөлөх дайсны муу нөлөөнөөс хамгаалах үүнээс илүү найдвартай хамгаалалтыг би мэдэхгүй.” (“Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан,” *Ensign* эсвэл 2012 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 93–94).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар дараах урилга ба амлалтыг өгсөн:

“Елиагийн сүнсний талаар сурч, үүнийг мэдрэхийг Сүмийн залуучуудаас би хүсэж байна. Түүнчлэн тэд өвөг дээдсийнхээ тухай сурч мэдэн, тэднийг эрж хайн, *нас барагсдынхаа* өмнөөс баптисм хүртэхэд өөрсдийгөө бэлтгээсэй хэмээн хүсэж байна (С ба Г 124:28–36-г үзнэ үү). Мөн бусад хүнд гэр бүлийн түүхээ олж мэдэхэд нь туслахыг би тэдэнд уриалж байна.

“Та үүнийг хийх аваас таны зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно. Абрахам, Исаак, Иаков нартай хийсэн амлалтууд та нарын зүрх сэтгэлд суух болно. Таны патриархын адислал, түүн дээр мэдэгдсэн уг гарал таныг эдгээр эцэгтэй тань холбож, танд илүү утга учиртай болж ирнэ. Та өвөг дээдсээ илүү хайрлаж, тэдэнд илүү их талархах болно. Аврагчийн талаарх таны гэрчлэл илүү гүн гүнзгий, бат бөх болно. Та нар өсөн нэмэгдэж буй дайсны нөлөөнөөс хамгаалагдах болно гэдгийг би та нарт амлаж байна. Та энэхүү ариун нандин ажилд оролцож, үүнийг хийх хүсэлтэй болсноор залуу насандаа, мөн амьдралынхаа турш хамгаалагдах болно” (“Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно,” *Ensign* эсвэл 2011 оны 11-р сарын *Ерөнхий чуулган*, 26–27).